



**БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
XI ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 07 сарын 07 өдөр

Дугаар XI/H

Булган сум

Булган сумын газар зохион байгуулалтын
2022 оны төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн XI хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөнд оруулах нэмэлт өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

2. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарч, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад сурталчлах ажлыг шуурхай зохион байгуулж, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл болон Хот суурин, дэд бүтцийн асуудал эрхэлсэн Хорооны дарга, гишүүдэд даалгасугай.

ДАРГА



Б.ГАНЗОРИГ